



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ард түмний хүч намын дарга
өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Батзориг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ард түмний хүч намаас гаргасан “Намын даргын мэдээлэлд өөрчлөлт оруулж, намын ээлжит бус Бага чуулганы хуралдаанаар сонгогдсон Л.Гүндалайг намын даргаар бүртгүүлэх” өргөдлийг шүүгч Д.Батбаатарын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ард түмний хүч намын дарга Л.Аззаяа 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн өргөдөлдөө: “Ард түмний хүч намын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус Бага чуулганы хуралдаанаар Ард түмний хүч намын дарга Л.Аззаяаг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлж, намын даргаар Л.Гүндалайг сонгож батлах шийдвэр гаргасан болно. Иймд Ард түмний хүч намын даргын бүртгэлээс Л.Аззаяаг хасаж, намын даргаар Л.Гүндалайг бүртгэж өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ард түмний хүч намын дарга өөрчлөгдсөнийг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана”, “... 15.2.4 намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага ... сонгоно” гэж тус тус заажээ.

Ард түмний хүч намын дүрмийн 9.2.4-т “Бага чуулганы хуралдааныг Намын дарга, Тэргүүлэгчдийн санаачилгаар, эсхүл намын Бага чуулганы гишүүдийн

гуравны нэг шаардсанаар зарлан хуралдуулж болно”, 9.2.3-т “Бага чуулганы ээлжит хуралдааныг хоёр жил тутам зарлан хуралдуулах бөгөөд шаардлагатай бол ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно” гэж тус тус заасны дагуу намын дарга Л.Аззаяа нь 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Ээлжит бус Бага чуулган зарлан хуралдуулах, комисс томилох тухай” 01 дүгээр тушаалаар намын ээлжит бус Бага чуулганы хуралдааныг 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зарлан хуралдуулжээ.

Өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудаас үзвэл Бага чуулганы хуралдаанаар Ард түмний хүч намын дарга Л.Аззаяагийн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тухай хүсэлт, намын даргаар Л.Гүндалайг сонгох тухай асуудлуудыг хэлэлцэж, намын даргын үүрэгт ажлаас Л.Аззаяаг чөлөөлж, Л.Гүндалайг томилсон 03, 04 дүгээр тогтоолуудыг баталсан нь тухайн намын Бага чуулганы эрх хэмжээнд байна.

Мөн Ард түмний хүч намын Бага чуулганд нийт 10 гишүүний 7 нь оролцож, хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар холбогдох шийдвэрийг гаргасан нь хууль болон намын дүрмийн 9.2.2.7-д “Их чуулганы чөлөөт цагт намын дарга орон гарвал Бага Чуулганд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар шинэ даргыг сонгох”, 9.2.6-д “Нийт гишүүдийн олонх нь оролцож байгаа бол Бага чуулганыг хүчинтэйд тооцно” гэж заасантай нийцжээ.

Иймд хүсэлтийг хангаж холбогдох бүртгэлийг хийх нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Ард түмний хүч намын даргаар Л.Гүндалайг бүртгэсүгэй.

2.Улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг төрийн сангийн 100200700941 тоот данснаас гаргуулж Л.Аззаяад буцаан олгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР